

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА,
ХЭМЖЭЭ БАТАЛСНААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮРЭН
ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2022/16-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Э.Бат-Эрдэнэ

Аудитор

З.Даваадорж

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2022 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Ерөнхий мэдээлэл**

Бүлэг А. Хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан үндсэн шаардлагад нийцүүлэн төлөвлөхгүй байгаагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр ашиг буурсан байна.

А.1. Хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан үндсэн шаардлагад нийцүүлэн төлөвлөхгүй байна.

А.2 Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Бүлэг Б. Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.1 Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ батлагдсанаас худалдан авах ажиллагаа удааширсан байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг бүрэн хэмжээнд арилгаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХАА	Худалдан авах ажиллагаа



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/06

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны A/28 дугаар тушаалын 1.2 дахь хэсэг, 2018 оны A/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны A/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2 дахь, 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газарт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Э.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг), аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан), аймгийн Засаг даргын Тамгын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ариунбат), Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсоргодог), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Оюунтуяа) нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр), ахлах аудитор (Э.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитыг баг /З.Даваадорж/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд” Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар 2021 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч түүний харьяа Засаг даргын Тамгын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн хяналтын төв болон бусад холбогдох төрийн байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан

тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитор О.Ганболд, З.Даваадорж нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүчин зүйлс: Орон нутаг дахь Төрийн аудитын газар нь төрөлжсөн хэлбэрээр аудитыг гүйцэтгэх боломжгүй байдаг тул аудитын хугацаанд санхүүгийн тайлангийн аудитууд давхцан аудитыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байлаа.

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2021 оны төсвийг баталсан бөгөөд тус тогтоолд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг батлаагүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаар 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

Хөвсгөл аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,457.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шилжих 4, шинээр эхлэх 941.5 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2,398.9 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртөг, тайлант онд санхүүжих дүнг графикаар харуулав. График-1



БҮЛЭГ 1:

Хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан үндсэн шаардлагад нийцүүлэн төлөвлөхгүй байгаагаас хөрөнгө оруулалтууд бүрэн хэрэгжихгүй байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан үндсэн шаардлагад нийцүүлэн төлөвлөхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 онд шинэчлэгдэн батлагдаж уг хуулийн хүрээнд өмнө нь батлагдаж байсан богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон байна. Хөвсгөл аймгийн хувьд аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01, 02 дугаар тогтоолоор дунд хугацааны бодлогын баримт бичиг “Хөвсгөл аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн 5 чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэргийг баталсан байна. Харин богино хугацааны буюу тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаас боловсруулж өргөн бариагүй тул ИТХ батлаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан 12 төсөл арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна. Бодлогын баримт бичгийн нийцлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хөвсгөл аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн 5 чиглэл
2.1	Ханх хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын орон сууц	4.1.9, 5.3.6	1.1.2.3, 6.1.3
2.2	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах	5.3.6	4.2.6
2.3	Хөгжимт драмын театрын дээврийн засвар	1.1.2	2.9.3
2.4	АЗДТГ-ын цэвэр, бохир ус халаалтын шугамын засвар	5.3.6	4.2.6
2.5	Мөрөн сумын доторх нийтийн тээврийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	8.2.1	3.9.4
2.6	Баяр наадмын талбайн урд асрын засвар	1.1.2	2.2.4,
2.7	Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар	2.2.8	2.1.11
2.8	"Хашаандаа сайхан амьдаръя" төслийн зөвлөх үйлчилгээ	8.1.2	3.10.4
2.9	"Гудамж" төслийн зөвлөх үйлчилгээ	8.1.2	3.10.4
2.10	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	6.3.1	5.6.3
2.11	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн цахим хуралдаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмж худалдан авах	5.1.1	4.1.2, 4.2.6
2.12	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах	5.3.6	4.2.6

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 12 төсөл, арга хэмжээний нэгээс бусад төсөл арга хэмжээг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй байна. Тухайлбал:

- ❖ Ханх хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын орон сууцны барилгын ажлыг Мэргэжлийн хяналтын байгууллагаас татгалзсан учир зогсоосон байна.

Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн нэг төсөл, арга хэмжээ нь “Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар” төсөл арга хэмжээ байна.

Төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, хэрэгжүүлэх дараалалд олон нийтийн санал аваагүй байна.

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хянахад төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, хэрэгжүүлэх дараалалд олон нийтийн санал аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 “хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;” дахь заалттай нийцэхгүй байна.

А.2. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Зураг, төсөв нь батлагдаагүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй 277.1 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөв нь батлагдаагүй дараах төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- ❖ Ханх хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын орон сууц
- ❖ Хөгжимт драмын театрын дээврийн засвар
- ❖ Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар
- ❖ Цагааннуур суманд цагаан засаг үржүүлгийн судалгааны байр барих
- ❖ Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ дэх заалттай нийцээгүй байна.

Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах төсөл арга хэмжээ баталсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна

¹ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний хэрэгжилт 41.2 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийг дараах байдлаар баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих
1	АЗДТГ-ын Соёмбо танхимын их засварын дуусгалтын ажлын барьцаа	2018	2021	184.3	12.9
2	Эрчим-2 амралт сувиллын газарт шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт	2018	2021	125.0	3.1
3	Хөгжимт драмын театрын их засвар	2020	2021	298.5	98.5
4	Аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2020	2022	849.5	200.0
5	Ханх хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын орон сууц	2021	2021	34.4	34.4
6	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах	2021	2021	195.0	195.0
7	Хөгжимт драмын театрын дээврийн засвар	2021	2021	100.0	70.0
8	АЗДТГ-ын цэвэр, бохир ус халаалтын шугамын засвар	2021	2021	70.0	70.0
9	Мөрөн сумын доторх нийтийн тээврийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	2021	2021	50.0	50.0
10	Баяр наадмын талбайн урд асрын засвар	2021	2022	229.4	20.0
11	Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар	2021	2022	50.0	40.0
12	"Хашаандаа сайхан амьдаръя" төслийн зөвлөх үйлчилгээ	2021	2021	15.0	15.0
13	"Гудамж" төслийн зөвлөх үйлчилгээ	2021	2021	15.0	15.0
14	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	2021	2021	15.0	15.0
15	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн цахим хуралдаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмж худалдан авах	2021	2021	90.0	90.0
16	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах	2021	2022	77.7	45.2
	НИЙТ			2,398.9	974.1

Төсөл, арга хэмжээний 2021 онд санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулбал хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний 41.2 хувийг хэрэгжүүлсэн ба 58.8 хувийг тайланд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн цахим хуралдаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмж худалдан авах" төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны явцад Сангийн яамнаас зогсоосон.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолт ажлын даалгаваргүй төсөл арга хэмжээг баталснаас хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал:

❖ "Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих" төсөл арга хэмжээг зураг төсөвгүй байхад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд оруулж баталсан ба зураг төсвийг нь хийлгэх үйл ажиллагааг тайлант онд зохион байгуулснаас тухайн ажлын худалдан авах ажиллагаа оройтсон байна.

- ❖ Мөрөн сумын доторх нийтийн тээврийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ, “Хашаандаа сайхан амьдаръя” төслийн зөвлөх үйлчилгээ, “Гудамж” төслийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврууд огт боловсруулагдаагүйгээс он дамжсан байна.
- ❖ Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн цахим хуралдаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 тогтоолд нийцүүлэлгүй баталснаас Сангийн яамнаас зогсоосон байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрахад нөлөөлж буй зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын боловсруулалтад хөрөнгө оруулалт хариуцсан ХОХБТХ-ийн оролцоо хангалтгүй байгаа нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна. Үүнд ХОХБТХ-ийн орон тоо дутуу, хүний нөөцийн оновчтой бодлого баримтлаагүй хүчин зүйлсээс гадна чиг үүргээ хэрэгжүүлж буй арга барил нөлөөлж байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т зааснаар хөрөнгө оруулалт нь тухайн шатны төсөвт хамаарах өмч үүсгэх шинжтэй байдаг. Батлагдсан төсөл арга хэмжээг хянан үзэхэд өмч үүсгээгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 2:

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГУУЛЖ, ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

Б.1. Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ батлагдсанаас худалдан авах ажиллагаа удааширсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХАА-ны эрх шилжүүлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих төсөл арга хэмжээний ХАА-ны эрхийг харьяа шатны төсөв захирагч нарт шилжүүлээгүй байна.

ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйц байдлаар ХАА-г зохион байгуулаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр баталсан. ХАА-ны үр дүнд шинээр хэрэгжихээр батлагдсан 12 төсөл, арга хэмжээнээс дараах 5 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч сонгон шалгаруулж ажилласан байна. Үүнд:

- ❖ Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин худалдан авах
- ❖ Хөгжимт Драмын театрын дээврийн засвар
- ❖ АЗДТГ-ын цэвэр, бохир ус, халаалтын шугамын засвар
- ❖ Баяр наадмын талбайн урд асрын засвар
- ❖ Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн дээврийн засвар

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний ХАА дараах шалтгаанаар удааширсан байна. Үүнд:

- ❖ Зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээнүүд батлагдсан
- ❖ Төсөв батлагдсан өдрөөс хойш үнэлгээний хороо байгуулах тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах эрх олгох, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зэрэгт 10-20 хоногийн хугацааг зарцуулж хугацаа алдсан байна. Тухайлбал: Захиалагч хамгийн эхний гэрээг 2021 оны 11 сарын 03-ны өдрөөс байгуулсан бөгөөд энэ нь барилга байгууламж, засварын ажил тайлант онд гүйцэтгэгдэх боломжийг хангахгүй хугацаа байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1², 28 дугаар зүйлийн 28.2³ дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн төсвийн тодотголоор Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.1.5⁴-д заасны дагуу 3 дугаар хавсралтаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг, 8 дугаар хавсралтаар ХАА-ны төлөвлөгөөний хамт баталж хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна.

Аймгийн ТЕЗ-аас өргөн баригдаж ИТХ-ын тогтоолоор батлагдсан төлөвлөгөө нь цаг хугацааны дараалалгүй, ХАА-ны хугацаа баримтлаагүй зэрэг алдаатай боловсруулагдсан байна.

Төсөвт тодотгол орсныг үндэслэн ТЕЗ нь ХАА-ны төлөвлөгөөг тодотгон батлаагүй аймгийн ОНӨГ-ын дарга нь 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр ХАА-ны төлөвлөгөөг тодотгон баталсан нь Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.11⁵-д заасантай нийцэхгүй, ТЕЗ-ийн эрх, үүргийг хөндлөнгөөс хэрэгжүүлсэн үйлдэл болсон байна.

ХАА-ны төлөвлөгөөг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасны дагуу ТЕЗ цаасан болон цахим хэлбэрээр баталж ажиллах шаардлагатай байна.

Захиалагч нь 2021 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил үйлчилгээ худалдан авах 874.0 сая төгрөгийн 8, батлагдсан төсөл арга хэмжээний зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний 3.1 сая төгрөгийн 2 нийт 10 худалдан авах ажиллагааг зохион байгуулж 644.6 сая төгрөгийн төсөвтэй 7 ХАА-нд 629.6 сая төгрөгийн гэрээ байгуулж 15.0 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргаж ажилласан байна. ХАА-нд баримтлах журмыг төсөвт өртгийг үндэслэн хуульд заасны дагуу тогтоож нээлттэй тендер 3, харьцуулалтын аргаар 5, шууд гэрээ

² 6.1. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

³ 28.2. Тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ.

⁴ 7.1.5 худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх

⁵ 3.11. Тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийснээс хойш ажлын 10 хоногт багтаан захиалагч төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь өөрчлөлтийг хянаж, цахим системээр батална.

байгуулах аргаар 2 ХАА зохион байгуулсан байна Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны тайланг төлөвлөгөөнөөс зөрүүтэй гаргасан байна.

Хөвсгөл аймгийн ТЕЗ-нь 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/130 тоот албан бичгээр Сангийн яаманд хуульд заасан хугацаанд нь хүргүүлсэн байна. Захиалагч нь 2021 оны ХАА-ны төлөвлөгөөнд 941.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгасан. Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.5⁶-д зааснаар тайланг гаргахдаа төлөвлөгөөнд батлагдсан бүх төсөл арга хэмжээний хэрэгжсэн, хэрэгжээгүй шалтгааныг ХАА-ны тайланд тусгах ёстой. Гэтэл орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХАА-ны тайланг гаргахдаа 941.5 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээний тоогоор биш 829.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээний ХАА-ны мэдээг тайлагнасан байна. Дараах 2 төсөл, арга хэмжээг ХАА-ны тайланд тусгаагүй байна. Үүнд:

1. “Ханх хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын орон сууц” төсөл арга хэмжээ
2. “Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах” төсөл арга хэмжээ

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэсэн байна.

Тайлант онд батлагдсан төсөл, арга хэмжээнээс 314.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шилжих, 394.1 сая төгрөгийн шинээр хэрэгжүүлэх 5 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд бусад төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Гэрээний дүн /сая.төг/	2021 онд санхүүжсэн дүн	Дараа онд шилжсэн үлдэгдэл
Шилжих хөрөнгө оруулалт					
1	АЗДТГ-ын Соёмбо танхимын их засварын ажил	Сондоргоо ХХК	12.9	12.9	0
2	Эрчим-2 амралт сувиллын газарт шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт	Тэргүүн сонголт ХХК	3.1	3.1	0
3	Хөгжимт драмын театрын их засвар	Хөвсгөл булаг ХХК	298.5	98.5	0
4	Аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мөрөн сумын хатуу хучилттай авто зам барих ажлын санхүүжилт	Хүслэнт бүтээмж ХХК	849.5	200.0	400.0
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт					
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин худалдан авах	Баян-Өндөр ХХК	194.5	194.5	0

⁶ “Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.”

6	Хөгжимт драмын театрын дээврийн засвар	Эндус Эрхэт ХХК	90.6	70.0	20.6
7	АЗДТГ-ын цэвэр, бохир ус, халаалтын шугамын засвар	Зэвт номгонт ХХК	69.6	69.6	0
8	Баяр наадмын талбайн урд асрын засвар	Бунбах ХХК	224.9	20	204.9
9	Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар	Хөх гүрэн констракшн ХХК	49.5	40	9.5
НИЙТ ДҮН			1,793.1	708.6	635.0

Шилжих хөрөнгө оруулалтын тухайд: Тайлант онд батлагдсан 4 төсөл, арга хэмжээнээс 114.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн бөгөөд аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөрөн-Улиастай чиглэлийн 1.6 км хатуу хучилттай зам барих ажилд тухайн онд батлагдсан 200.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Зам засварын ажил бүрэн хийгдэж дуусаагүй тул 2022 онд шилжин хийгдэж байна.

Шинээр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын тухайд: Тайлант онд батлагдсан 5 төсөл, арга хэмжээнээс 264.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бөгөөд бусад төсөл арга хэмжээ нь тухайн онд батлагдсан санхүүжилтийн хүрээнд ажлыг гүйцэтгэн он дамжин хэрэгжиж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэгдсэн байна. Мөн Барилгын тухай хуулийн 14.8⁷-д заасны дагуу төсөл, арга хэмжээний барьцааг бүртгэх, чөлөөлөх ажлын тооцооллыг үнэн зөв хийсэн байна. Тайлант онд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний барьцаа болох 41.0 сая төгрөгийг “100170051350 Хө.Барьцаа ХО” тоот дансанд байршуулсан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний банкны баталгааг хуульд заасан хувь хэмжээгээр байршуулж төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авсны дараа бүрэн олгосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 194.5 сая төгрөгийн Ланд-200 автомашин худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дахь заалттай нийцэхгүй байна. Энэхүү зөрчилтэй холбогдуулан санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Цаашид орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, Засгийн газраас гарсан тогтоол шийдвэр болон холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Захиалагч “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг бүрэн хариуцна.

⁷ Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2⁸, 2.8⁹-д заасны дагуу аймгийн Засаг дарга “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй 271.9 сая төгрөгийн гэрээ байгуулан захиалагчийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд гүйцэтгэгдсэн 6 төсөл арга хэмжээний 5 төсөл арга хэмжээнд “Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлсэн байна. Захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлж, үе шатны хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилган арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн Засаг дарга нь зөвлөх үйлчилгээ үзүүлэгч буюу үе шатны хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй, тухайн жилд гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасан хугацаанд үнэлээгүй байна.

Б 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

Орон нутгийн төсвөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг тухайн жилд санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолд заасан төсөвт өртөгт багтаан бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна. Тайлант онд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн 708.6 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн боловч өмнөх онд хэрэгжсэн “Хөгжимт драмын театрын засвар”-ын ажил нь зураг, төсвийн дагуу хийгдээгүй ашиглагч талаас гүйцэтгэсэн ажлын чанар байдалд сэтгэл дундуур байна. Энэ нь тухайн барилгын засварын төсвийг үндэслэлтэй тооцолгүй баталсан нөгөө талаас мэргэжлийн боловсон хүчин, хүн хүчний нөөц дутмаг аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж гүйцэтгүүлснээс шалтгаалжээ. Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа өмнө нь гүйцэтгэсэн ажлын чанар, байдал, мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайтар нягтлах, төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэж буй аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцож ажиллах шаардлагатай байна.

Ашиглалтад орсон барилга байгууламж, шугам сүлжээ, автомашиныг бүртгэлд тусган хэвийн ашиглаж байна.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах, данс бүртгэлд тусгах, гүйцэтгэлийн чанарын баталгааны

⁸ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

⁹ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.(Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмсэн)

барьцаа хөрөнгө чөлөөлөх зэрэг арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг тайлагнах чиг үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн ОНӨГ нь чиг үүргийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн өмчид хүлээн авч данс бүртгэлд тусгуулсан байна.

Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг бүрэн хэмжээнд арилгаагүй байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар 2 албан шаардлага, 21 зөвлөмж өгч ажилласан бөгөөд цар тахлын үеийн хүндрэлээс шалтгаалан 2 албан шаардлагын биелэлтийн хугацааг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд сунгасан, зарим зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн боловч аудитын хүрээнд зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ батлан хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарч байна. Иймд дээрх зөрчилтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын дарга Г.Мөнгөнхуяг, аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан нарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Төрийн аудитын газраас Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөт байдлыг хангуулах чиглэлээр жил бүр аудит хийн зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байгаа ч зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа дутагдал давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн захиргааны зарим байгууллагууд идэвх санаачилгагүй ажиллаж байгаа нь дээрх зөрчил, дутагдлууд давтагдан гарах үндэслэл болж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээг баталснаас хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн худалдан авах ажиллагаа удааширч, хөрөнгө оруулалтууд бүрэн хэрэгжихгүй байна.
2. ХОХБТХ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
3. Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ батлагдсанаас худалдан авах ажиллагаа удааширсан байна.
4. Захиалагч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг тооцож, үнэлээгүй байна.
7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөт байдлыг хангуулах чиглэлээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа дутагдал давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн захиргааны зарим байгууллагууд идэвх санаачилгагүй ажиллаж байгаа нь дээрх зөрчил, дутагдлууд давтагдан гарах үндэслэл болж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авсан эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг батлах

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авсан эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг төлөвлөх.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль журамд нийцүүлэн цаасан болон цахим хэлбэрээр батлах.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг гүйцэтгэж буй байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг тооцож, үнэлэх.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбатад:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авсан эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг төлөвлөх
2. Худалдан авах ажиллагааны явцад үүсч байгаа хугацааны алдагдлыг арилгах чиглэлээр арга хэмжээ авч, төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжихүйц гэрээг байгуулах
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож ажиллах.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:

1. Орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засаг болон нийгмийн үзүүлэлтүүдэд нөлөөлөхүйц, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч төлөвлөх.
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд, хэрэгжилт үр дүнг хариуцах хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.
3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсоргодогт:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль журамд нийцүүлэн цаасан болон цахим хэлбэрээр аймгийн Засаг даргаар батлуулж ажиллах
2. Худалдан авах ажиллагааны явцад үүсч байгаа хугацааны алдагдлыг арилгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, өмнө нь гүйцэтгэсэн ажлын чанарыг нягтлан, үнэлж ажиллах.

Зөрчлийн жагсаалт:

/Сая.төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй ажлын даалгаваргүй, хууль журамд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн.	471.6					3	471.6
2	ХОХБТХ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.						1	
3	ТЕЗ нь ХАА-ны төлөвлөгөөг тодотгон батлаагүй						1	
4	Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ батлагдсанаас худалдан авах ажиллагаа удааширсан.						4	
5	Төсөв батлагдсан өдрөөс хойш үнэлгээний хороо байгуулах тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах эрх олгох, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зэрэгт 10-20 хоногийн хугацааг зарцуулж хугацаа алдсан						1	
6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг тооцож үнэлээгүй.						1	
7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа өмнө нь гүйцэтгэсэн ажлын чанар, байдал, мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайтар нягтлаагүй байна.	298.5					2	298.5
НИЙТ ДҮН		770.1					13	770.1